

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР****АКТ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 1/18 ҮАТ-САТ/2014/-01/СМА-Тс

Орлого төвлөрүүлэх тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Засгийн газрын нөөц сангийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын тогтоолоор 2013 онд олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл буюу хэмнэлтийн нийт 609,201,687.96 төгрөгийг холбогдох нэр бүхий 8 байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулан авлагаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д "Төсвийн тогтворжуулалтын санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ", 9.2.3-д "Засгийн газрын нөөц сангийн болон эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр" гэж заасныг зөрчиж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэж заасан заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-д "төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавина гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын тогтоолын хэмнэлтийн 609,201,687.96 төгрөгийг 2014 оны 5 дугаар сарын 30-ны дотор Монгол банкин дахь Тогтворжуулалтын сангийн 3402024 тоот дансанд татан төвлөрүүлэх.
2. Дээрх хөрөнгийг төвлөрүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт хариуцуулав.

**АКТЫГ****ЗӨВШӨӨРСӨН:**

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН
ГАЗРЫН ДАРГА /Ч.ТАВИНЖИЛ/

САНХҮҮЖИЛТ, ТАЙЛАН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА /Ц.АРИУНСАНАА/